



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/957

Мандалговь

Аймгийн шинжлэх ухаан, технологийн
салбар зөвлөлийг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Инновацийн тухай хуулийн 11 дугаар зүйлийн 11.1 заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шинжлэх ухаан, технологи, инновацийг хөгжүүлэх бодлого, тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, орон нутгийн захиалгат төслийг дэвшүүлэх, захиалах, гүйцэтгэлийн явцад хяналт тавих, үр дүнг хүлээж авах, үнэлэх, үйлдвэрлэл үйлчилгээнд нэвтрүүлэх, инновацийн төсөл, хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх, шинжлэх ухааны шинэ мэдлэг, инноваци, технологийн ололтыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах аймгийн шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга: М.Анхбаяр (Аймгийн Засаг даргын орлогч)

Зөвлөлийн орлогч дарга: Ц.Уранбямба (Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга)

Нарийн бичгийн дарга: - (Боловсрол, шинжлэх ухааны газрын шинжлэх ухаан, технологи, инноваци, дээд боловсрол, мэргэжлийн боловсролын сургалт хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: - (Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Ж.Уянга (Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Ю.Цолмон (Аймгийн политехник коллежийн захирал)

Б.Туяагэрэл (Монгол Улсын Их Сургуулийн Хэрэглээний Шинжлэх Ухааны Их Сургуулийн дэд профессор)

О.Ганхуяг (Ган-илч ХХК-ий гүйцэтгэх захирал)

Б.Ням (Мандал шилтгээн ХХК-ий захирал)

Н.Батбаяр (Худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга)

О.Эрдэнэтөгс (Иргэний нийгмийн байгууллагуудын сүлжээ, Төрийн бус байгууллагын тэргүүлэгч)

Ж.Батбилэг (Хүнс, хөдөө аж ахуйн газрын мал үржлийн албаны дарга бөгөөд аймгийн ерөнхий мал зүйч)

П.Уртнасан (Сум дундын ойн ангийн ахлах мэргэжилтэн)

2. Зөвлөлийн дүрмийг хавсралтаар баталсугай.

4822100837

3. Зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр батлуулж, хэрэгжилтийг хангаж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Анхбаяр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ